



20-07-36-01

ДАРХАН-УУЛ АЙМАГ
“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-НИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 117

Журам баталж мөрдөх тухай

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3.1 дэх заалт, компанийн ажлын байруудад учирч болох аюулыг судалж түүний дагуу эрсдлийг арилгах, бууруулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих болон ХАБЭА-н тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. “Дарханы дулааны сүлжээ ТӨХК-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн удирдлагын журмыг хавсралтаар баталж 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг жил бүрийн XII сарын 25-ны дотор илтгэх хуудсаар гаргаж гүйцэтгэх захиралд танилцуулж байхыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер (П.ЭРДЭНЭЧИМЭГ)-т даалгасгай.

Хавсралт 13 хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ГАНТУУЛ



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

1. ЗОРИЛГО

1.1. Энэхүү журмын зорилго нь ДДС ТӨХК (компани)-ийн алба, хэлтсүүдийн объектууд, ажлын байруудад учирч болзошгүй аюулыг урьдчилан судалж түүний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөө боловсруулах, арга хэмжээний санхүүжилтээ төлөвлөх, аюулгүй ажиллагааны зөв удирдлага зохион байгуулалттай болох, ажлын байранд учирч болох аюул ослыг арилгах, хяналт тавих болон ажил олгогч “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-д заасан үүргээ хэрэгжүүлэхэд чиглэл өгөхөд оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Энэхүү журам нь компанийн хэмжээнд хэрэгжүүлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны зохион байгуулалт, бөгөөд компанийн бүх алба, хэлтэсүүдэд хамаарна.

2.2. Энэхүү журмаар дараах үйл явцуудыг тодорхойлно. Үүнд:

- ажлын байр, түүний орчинд байж болох болон ажил гүйцэтгэх үед үүсэж болох бүх аюулыг илрүүлж тогтоох;
- илрүүлж тогтоосон аюулын эрсдэлийг үнэлэх, эрсдэл нь зөвшөөрөгдөх эсэхийг тогтоох;
- илрүүлж тогтоосон аюулыг аль болох богино хугацаанд устгах, мэдээлэх;
- зөвшөөрөгдөх бус хэмжээнд байгаа эрсдэлийн түвшинг бууруулахад чиглэсэн хяналтыг тодорхойлох;
- тодорхойлсон хяналтын арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх.

2.3. Энэхүү журмаар зохицуулах ХАБЭА-н эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд компанийн, гэрээт байгууллагын болон гэрээгээр ажиллагсдын бүхий л талын оролцоог хангаж, тэдгээрт ХАБЭА-н эрсдэлийн удирдлагын талаарх мэдээ мэдээллийг түгээн ажиллана.

3. ИШ ТАТСАН БАРИМТ БИЧИГ

3.1. МУ-ын Хөдөлмөрийн тухай 1999 оны 05 дугаар сарын 14-ний, ХАБЭА-н тухай хууль 2015 оны 05 сарын 14-ны өдрийн нэмэл оруулсан;

3.2. МУ-ын MNS OHSAS 18001:2012 стандарт, холбогдох бусад үндэсний стандарт, дүрэм, журам;

3.3. Компанийн ХАБЭА-н бодлого, удирдлагын тогтолцооны журам болон ХАБЭА-н бусад журам, дүрэм, заавар.

3.4. Монгол улсын хөдөлмөрийн сайдын 2015 оны 12-дугаар сарын 28-ны өдрийн А/295 дугаар тушаалын хавсрал

4. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

4.1. Энэхүү журамд заасан нэр томъёог энэхүү журмын 3-т заасан хууль эрх зүйн акт, стандартад тодорхойлсоноор ойлгоно.

5. АЮУЛЫГ ИЛРҮҮЛЖ ТОГТООХ НЬ

5.1. Ажлын байранд болон түүний орчинд орших, түүнчлэн ажил гүйцэтгэх үед 36/2019
учрах бүх аюулыг үндсэн 4 төрөлд хуваан авч үзнэ. Үүнд:



- физикийн аюул (эргономикийн болон бичил цаг уурын сөрөг хүчин зүйлс, цацраг туяа, хөдөлгөөнт тоног төхөөрөмж, өргөн тээвэрлэх машин механизм, даралтат сав, г.м.);
- химийн аюул (химийн хорт болон аюултай бодисууд, г.м.);
- биологийн аюул (нян, вирус, хорхой, шимэгч, г.м.);
- сэтгэл зүйн аюул (ажлын ачаалал, ээлжийн хуваарь, хэт их хүчний ажил, удирдлага болон хамт олны зүгээс үзүүлэх таагүй хандлага, стресс, г.м.).

5.2. Аюулыг илрүүлж тогтооход аюул учирч болох дараах 11 чиглэлийн асуудлыг харгалзан үзнэ. Үүнд:

- байнгын болон байнгын бус төрлийн үйл ажиллагаа;
- ажлын байранд нэвтрэх эрх бүхий бүх ажилтнууд (гэрээгээр ажиллагсад болон зочилж байгаа хүмүүс мөн хамаарна)-ын явуулах үйл ажиллагаа;
- дадал зуршил, чадвар болон бусад хүний хүчин зүйлс
- компанийн хяналтанд ажлын байрандаа байгаа ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй ажлын байрнаас гадна ажлын байранд тогтоогдсон аюулууд;
- компанийн хяналтан дор явагдаж байгаа ажилтай холбоотой ажлын байрны орчинд үүсэх аюул;
- компаниас эсвэл өөр этгээдээс хангаж байгаа ажлын байран дахь дэд бүтэц, тоног төхөөрөмж, материал;
- компанид, түүний үйл ажиллагаанд эсвэл хэрэглэж байгаа материалд гарсан эсвэл гарах гэж байгаа өөрчлөлтүүд;
- ХАБЭА-н удирдлагын тогтолцооны өөрчлөлт болон түр зуурын өөрчлөлтийн улмаас үйл явц, үйл ажиллагаа болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл;
- эрсдлийн үнэлгээ болон шаардлагатай хяналтыг хэрэгжүүлэхэд хамааралтай хуулиар хүлээсэн холбогдох үүрэг;
- ажлын орчин, үйл явц, байгууламж, машин тоног төхөөрөмж, үйл ажиллагааны журам ба ажлын зохион байгуулалтын төсөл ба түүнчлэн тэдгээрийн хүний боломжид нийцүүлсэн байдал;
- ойр оршиж байгаа өөр бусад байгууллагын явуулж буй үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөлөл, аюулууд.

5.3. Ажлын байранд болон түүний орчинд орших, түүнчлэн ажил гүйцэтгэх үед учрах аюулыг дараах арга замаар илрүүлнэ. Үүнд:

- Гурван шатны хяналтын үзлэг шалгалт
- Аюултай тохиолдлын судалгаа (Алба хэлтсүүдийн бүртгэл судалгаанаас);
- Аюулыг мэдээлэх хуудас (Энэхүү журмын 9-р бүлэг, хавсралт №1-т харуулсан);
- Ажлын байрны үзлэг шалгалт, ажиглалт, ажилтнуудын санал;
- Бусад албан ёсны мэдээллүүд.

5.4. Ажлын байранд болон түүний орчинд орших, түүнчлэн ажил гүйцэтгэх үед учрах аюулыг илрүүлж тогтооход хавсралт №2-т харуулсан "Ажлын байр, орчны аюулын хяналтын хуудас"-ыг ашиглана.

5.5. Илрүүлж тогтоосон аюул бүрийн эрсдэлийг нь заавал үнэлнэ.


5.6. Шууд удирдах ажилтан нь илэрсэн аюул бүрийг хавсралт №3-т харуулсан эрсдэлийн үнэлгээний бүртгэлд бүртгэнэ.

6. ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ

6.1. Эрсдэлийг дараах тохиолдолд үнэлж бүртгэнэ. Үүнд:

- Ээлжит үнэлгээ:

- Алба, нэгж бүр дээр ажлын байр, орчин, тоног төхөөрөмжийн эрсдэлийн үнэлгээг тухайн алба, нэгжийн удирдлага, 1-р улиралд багтаан зохион байгуулна.



• Ээлжит бус үнэлгээ:

- Ажил гүйцэтгэх арга барил өөрчлөгдөх, шинэ төрлийн ажил гүйцэтгэх үед;
- Өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэх үед;
- Хэрэглэж буй технологи, машин, тоног төхөөрөмж, материал, бодис, хамгаалах хэрэгсэл өөрчлөгдөх, сайжрах, шинэчлэгдэхийн өмнө;
- Аюултай тохиолдлын нөхцөл байдал, шалтгааныг судлах үед;
- ХАБЭА-н хууль эрхзүйн акт, ХАБЭА-н дотоод баримт бичиг, тэдгээрийн шаардлага өөрчлөгдсөн үед;
- Хязгаарлагдмал орон зайд (худаг, газар доор, шугам хоолой дотор гэх мэт);
- Технологи болон машин тоног төхөөрөмжийн ажлын явцад аюултай нөхцөл байдал үүссэн бөгөөд үргэлжлүүлэн ажиллуулах шаардлагатай үед;
- Бусад шаардлагатай тохиолдолд.

6.2. Эрсдэлийн жил бүрийн ээлжит үнэлгээ хийх багийг тухайн ажлын байранд ажилладаг инженерийн төлөөлөл /И/, мэргэжилтэн /М/, ажилтан /А/-уудаас бүрдсэн, тухайн ажлын байрны нөхцөл, онцлогоос хамаарч 3–7 хүний бүрэлдэхүүнтэй дараах эрсдэлийн үнэлгээний ИМА баг гүйцэтгэнэ. Үүнд:

- Ажил олгогчийн инженерийн төлөөлөл /И/-д тухайн алба, хэлтэс, дарга, инженер, мастер байна;
- Мэргэжилтэн /М/-ий төлөөлөлд ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх сургалтанд хамрагдсан тухайн алба хэлтсийн ИТА байна (шаардлагатай тохиолдолд гэрээт байгууллагын ИТА-г оролцуулна);
- Ажилтан /А/-ы төлөөлөлд тухайн алба хэлтсийн хамт олноос сонгосон төлөөлөгч эсвэл хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэх туршлагатай нэг буюу хэд хэдэн ажилтан байна (шаардлагатай тохиолдолд гэрээт байгууллагын ажилтан болон гэрээгээр ажиллагсдыг оролцуулна).

6.3. Ээлжит бус үнэлгээг тухайн ажлыг удирдан хариуцсан болон шууд удирдах ажилтан 6.2-т заасан тухайн цехийн ИМА багийн хамт гүйцэтгэнэ.

6.4. Эрсдэлийг үнэлэхэд дараах шалгуурыг харгалзан үзнэ. Үүнд:

- аюул ба үр дагавар, магадлал;
- тухайн ажилтанд үзүүлэх нөлөөллийн үр дагаварын хор уршиг (бага хэмжээнээс эхлэн амь нас эрсдэх нөлөөлөл хүртэл);
- нөлөөллийн хэмжээ, цар хүрээ (аюулд нэгэн зэрэг өртөж болзошгүй ажилтны тоо);
- үүссэн аюулыг цаг тухайд нь илрүүлэн тогтоож, хариу арга хэмжээ авах боломж;
- холбогдох хууль тогтоомж, бусад эрхзүйн актаар тухайн эрсдэлийг зохицуулсан байдал;
- тухайн эрсдэлийг хянаж буй арга хэрэгсэл байгаа эсэх, тэдгээр нь найдвартай эсэх, г.м.

6.5. Эрсдэлийн үнэлгээг хавсралт №4-т харуулсан Монгол улсын хөдөлмөрийн сайдын Дугаар А/295 аргачилсан зөвлөмжийн дагуу хийнэ.

6.6. Эрсдэлийн үнэлэхэд эрсдэлийг хамгийн бодитой түвшинд үнэлэх ба эрсдэлийн хэмжээний талаар нэгдсэн үзэл бодолд хүрэхээр тооцож үнэлгээний баг ярилцаж нэгдсэн дүгнэлт хийнэ ба эрсдэлийг хэт дөвийлгөх эсвэл хэт бууруулахаас зайлсхийнэ.

6.7. Эрсдэлийн үнэлгээний үр дүнг хавсралт №3-т харуулсан эрсдэлийн үнэлгээний бүртгэлд бүртгэнэ. Бүртгэхдээ эрсдэлийн түвшинг бууруулах, хянах арга хэмжээ, гүйцэтгэх дэс дараалал, хугацаа болон бусад зүйлсийг тодорхойлно. Эрсдэлийн үнэлгээний бүртгэлийг холбогдох бүх ажилтнуудад танилцуулж, шаардлагатай бүх ажлын байруудад байрлуулна.

6.8. Эрсдэлийн үнэлгээний үр дүнгээр эрсдэлийн түвшин нь зөвшөөрөгдөх эсэх болон түүний хяналтыг тодорхойлох арга хэрэгсэл нь хангалттай байгаа эсэхийг шийдвэрлэнэ.

Хуульч Дугаар 36/2019

ДАРХАНЫ ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2019 оны 4 сарын 30

6.9. Эрсдэлийн үнэлгээний явцад тухайн ажлын байрны технологийн үйл ажиллагаанд, тэдгээрийн орчинд гарч болзошгүй гамшигтай холбоотой аюултай тохиолдлуудыг мөн тогтоож, эрсдэлийг нь үнэлж, аваар арилгах төлөвлөгөөнд тусгана.

7. ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ХЯНАЛТЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

7.1. Ажилтнууд ажлын байр, орчин, машин тоног төхөөрөмж, технологийн үйл ажиллагааны аюулыг илрүүлж арилгана. Аюулыг бүрэн арилгах боломжгүй үед ажил олгогч тухайн аюулаас учрах эрсдлийн түвшинг бууруулах арга хэмжээг авна.

7.2. Эрсдэлийн түвшинг бууруулахад ач холбогдол нь буурсан дарааллаар жагсаасан дараах үндсэн 5 хяналтын арга хэрэгслийг хэрэглэнэ. Үүнд:

- эрсдэлийг бүрмөсөн арилгах буюу аюулыг бүрэн арилгах, үгүй болгох (аюулыг газар дээр нь шууд арилгах, ажлын орчинд хүн байлгахгүй зорилгоор бүрэн автоматжуулах, г.м.);
- эрсдэлийг орлуулах буюу аюулгүй эсвэл аюул багатай технологи хэрэглэх (хор, аюул багатай бодис материалаар орлуулж хэрэглэх, хүн ажиллуулахаас илүү машин техник ажиллуулах, гар ажиллагааг механикжуулах ба автоматжуулах, г.м.);
- инженерийн хяналтыг хангах буюу инженерийн тусгай тоноглол хэрэглэх (машин, тоног төхөөрөмж дээр хүн гэмтээхээс хамгаалах тоноглол суурилуулах, дуу чичиргээ намсгагч тавих, хаалт хашилт тавих, агааржуулалтын систем, пайз цоожны систем хэрэглэх, г.м.);
- захиргааны хяналт удирдлагыг хангах буюу тэмдэг, тэмдэглэгээ, сэрэмжлүүлэг хэрэглэх, сануулах, анхааруулах, хориглох тэмдэг, тэмдэглэгээ, санамж байрлуулах, ажлын орчинд хүн нэвтрэхийг хязгаарлах, ажлыг аюулгүй гүйцэтгэх арга барил болон дарааллыг тогтоох, ажил гүйцэтгэх ажилтны мэдлэг боловсрол, дадлага туршлага, ур чадвар, зан үйл болон арга барилд тавигдах шаардлагыг тогтоож өгөх, заавар, дүрэм, журам, технологийн карт, ажил зохион байгуулах төсөл боловсруулж мөрдүүлэх, г.м.);
- хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх буюу тухайн тодорхой төрлийн эрсдэлээс бүрэн хамгаалах хувийн хамгаалах хэрэгслийг тогтоож хэрэглүүлэх, г.м.

7.3. Эрсдэлийн түвшин нь улаан бүсэд байх тохиолдолд уг ажил, машин тоног төхөөрөмж, технологийн үйл ажиллагааг зогсоож, эрсдлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн авч явуулсны дараа дахин эрсдлийг үнэлээд эрсдэлийн түвшин зөвшөөрөгдөх түвшинд хүртэл буурсан тохиолдолд ажиллахыг зөвшөөрнө.

7.4. Эрсдэлийн үнэлгээний бүртгэлд тухайн эрсдлийг бууруулах, хянах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой, бүрэн тодорхойлох ёстой. Бүртгэлд тодорхойлсон арга хэмжээг ажилтнууд гүйцэд хэрэгжүүлнэ.


7.5. Анхан шатны удирдах ажилтан нь ажлын даалгавар өгөхдөө тухайн ажлын байр, орчны болон ажлын эрсдэлийн үнэлгээний зэрэглэл, эрсдэлийг бууруулах арга хэмжээг ажилтанд танилцуулж, энэ тухай ажлын даалгаврын дэвтэрт тэмдэглэнэ.

8. ХЯНАЛТЫГ ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

8.1. Эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, ойлголтыг ХАБЭА-н бүх төрлийн сургалт, зааварчилгаагаар дамжуулан компанийн бүх ажилтнуудад өгнө.

8.2. Шууд удирдах ИТА-ууд нь аливаа ажил хийж эхлэхийн өмнө өөрийн удирдаж буй ажилчидтай ажлын байрны эрсдэлийг удирдах хяналтын арга хэрэгслийн талаар заавал ярилцлага хийнэ.

8.3. Ажилтан бүр өөрийн ажлын байрны эрсдэлийг удирдах хяналтын арга хэрэгслийн талаар мэдэх ба ажлын байранд болон ажил гүйцэтгэх явцад илэрсэн аливаа аюул, эрсдэл, гарсан аюултай тохиолдлын талаарх мэдээллийг анхан шатны удирдах болон ИТА-д мэдээлэх үүрэгтэй.



8.4. Ажилтан бүр илрүүлсэн аливаа аюул, эрсдэл, гарсан аюултай тохиолдлын талаар 5.3-т дурдсан аюулыг илрүүлэх арга хэрэгслүүдийг ашиглан мэдээлж, тэдгээрийг арилгуулах арга хэмжээ авахуулна.

8.5. Бүх шатны удирдах болон ИТА-ууд нь ажлын байранд болон ажил гүйцэтгэх явцад илэрсэн аюул, эрсдэл, гарсан аюултай тохиолдлын талаар мэдээлэх үед "үл буруутгах зарчим"-ыг баримтлан энэхүү мэдээлэх явдлыг хөхүүлэн дэмжиж, галархаж, урамшуулж, хүлээж авсан мэдээллийн дагуу аюул, эрсдэлийг арилгах, залруулах болон сэргийлэх арга хэмжээ авна. Мэдээлэх явдлыг үл ойшоож, түүний мөрөөр аливаа залруулах болон сэргийлэх арга хэмжээ авахгүй байхыг хориглоно.

8.6. Эрсдэлийг бууруулахаар тодорхойлсон хяналтын арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулж, хэрэгжилтийг хангана. Хэрэгжүүлсний дараа эрсдэлийг дахин үнэлж, шаардлагатай бол эрсдэлийн хяналтын арга хэрэгслийг дахин төлөвлөж хэрэгжүүлнэ, улмаар эрсдэлийг тогтмол бууруулах, ажлын байрны ХАБЭА-г дээшлүүлэх, тасралтгүй сайжруулах арга хэмжээг авна.

8.7. Тухайн оны эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг жил бүрийн 10-р сарын 15-ны дотор боловсруулж, Хяналтын хэлтэс-ХАБЭА инженертэй зөвшилцөж алба, нэгжийн даргаар батлуулна. Төлөвлөгөөний биелэлтийн явцын талаарх тайлан мэдээг улирал бүр Хяналтын хэлтэс-ХАБЭА инженерт хүргүүлнэ. Тухайн алба хэлтсийн дарга, Хяналтын хэлтэс-ХАБЭА инженер нь төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллана.

8.8. Тухайн оны эрсдэлийг бууруулсан ажлын тайланг жил бүрийн 12-р сарын 10-ны дотор Хяналтын хэлтэс-ХАБЭА инженерт хүргүүлнэ. Тайланд фото зураг (эрсдэлтэй ажлын байр, эрсдэлийг бууруулсан байдал, г.м.), ажилчдын эрсдэлийн талаарх нэмэлт санал зэргийг оруулсан байна. Хяналтын хэлтэс-ХАБЭА инженер нь компанийн бүх нэгжийн тайланг нэгтгэж, 12-р сарын 25-ны дотор компанийн хэмжээний тайланг гаргана.

8.9. Алба, хэлтэс нь тухайн оны эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд ноцтой буюу өндөр эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг тухайн оны ХАБЭА-н ажлын төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийн явцын талаарх тайлан мэдээг улирал бүр Хяналтын хэлтэст хүргүүлнэ. Хяналтын хэлтэс нь ХАБЭА-н ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллана.

8.10. Энэхүү журамд заасан үүргийг хэрэгжүүлээгүй ИТА, ажилтан, албан хаагч нарт холбогдох дүрэм журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.11. Ажлын байрны эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гаргаж дүгнэн, удирдлагын багийн хурлаар оруулж урамшуулал олгоно.

9. АЮУЛЫГ МЭДЭЭЛЭХ ХУУДСЫГ АШИГЛАХ ТУХАЙ

9.1 Нийтлэг үндэслэл


9.1.1. Компанийн хэмжээнд аюулыг илрүүлж тогтоох, арилгах, улмаар болзошгүй гэмтэл, эрүүл мэндийн хохирол, осол аваар гарахаас урьдчилан сэргийлэх ажилд ажилтан бүрийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

9.1.2. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд доорх загвар бүхий Аюулыг мэдээлэх хуудсыг ашиглана.

9.2. Аюулыг мэдээлэх хуудсыг хэрэглэх орчин

9.2.1. Аюулыг мэдээлэх хуудас, аюулыг мэдээлэх хуудсыг бүртгэх бүртгэл нь компанийн хэмжээнд нэг эх загвартай байх, загварыг хяналтын хэлтэс боловруулан захиалга өгнө. Аюулыг мэдээлэх хуудсыг хэвлүүлэх, хангах, нийлүүлэх үүргийг Хангамжийн хэлтэс хариуцан гүйцэтгэж, алба, хэлтсийн удирдлага Санхүү бүртгэлийн хэлтсээс авч аюулыг мэдээлэх хуудас байрлах дараах цэгүүдэд тараана. Үүнд:

- | | |
|------------------------------------|--------------------------------------|
| 1. Захигаа удирдлагын даргын өрөө; | 7. Диспетчерийн өрөө; |
| 2. Засварын албаны даргын өрөө; | 8. Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн байр; |
| 3. Ашиглалтын албаны даргын өрөө; | 9. Ашиглалтын 1 ба 2-р хэсгийн байр; |
| 4. Инженерийн албаны даргын өрөө; | 10. НС, ДХТ-үүдийн байранд; |



- б. Хэрэглэгчийн албаны даргын өрөө; 11. Эмчийн өрөө;
- в. Хангамжийн хэлтсийн даргын өрөө; 12. Хяналтын хэлтсийн өрөө.

9.2.2. Нэг аюулыг мэдээлэх хуудас нь 3 хувь бичигдэнэ. Мэдээлэгч нь аюул, осолд дөхсөн тохиолдол, түүнийг арилгах, устгах арга хэмжээний тухай мэдээллээ Аюулыг мэдээлэх хуудсанд асуултын дагуу бүрэн тодорхой бичээд, 1 хувийг өөртөө хадгалж, 1 хувийг ХАБЭА инженерт, үлдсэн 1 хувийг тухайн аюулыг устгах нэгжийн удирдлагад өгнө.

9.2.3. ХАБЭА инженер нь Аюулыг мэдээлэх хуудсыг хүлээн авч, бүртгэж аюулыг устгах шаардлагыг тодорхой хугацаа зааж тухайн алба, хэлтэс цехийн удирдлагад өгнө.

9.2.4. Аюулыг устгах шаардлага хүлээн авсан алба, хэлтэс, цехийн удирдлага заасан хугацаанд зөрчлийг устгуулж тайланг ХАБЭА инженерт гаргаж өгнө.

9.3. Хяналт, хариуцлага

9.3.1. Хяналтын хэлтсийн хяналтын Инженер Аюулыг мэдээлэх хуудасны мөрөөр гүйцэтгэх арга хэмжээний биелэлтэнд хяналт тавина.

9.3.2. Хяналтын хэлтэс нь компанийн хэмжээнд бүртгэгдсэн Аюулыг мэдээлэх хуудас, түүний мөрөөр гүйцэтгэсэн ажлын нэгдсэн судалгаа, дүн шинжилгээний мэдээг Алба, хэлтэс нь, аюулын төрлөөр ангилан гаргаж компанийн удирдлага, ХАБЭА-н орон тооны бус зөвлөл болон нийт хамт олонд хагас жилд тайлагнана.

9.3.3. Аюулыг устгах шаардлага өгөгдөөд заасан хугацаанд зөрчлийг арилгаагүй, чанаргүй устгаснаас осолд дөхсөн тохиолдол гарах, Аюулыг мэдээлэх хуудасны тайланг хугацаанд нь өгөөгүй бол тухайн алба, хэлтсийн удирдлагын сарын үр дүнгийн шагналыг ХАБЭА-д тооцох үзүүлэлтээс хасна.

ХАВСПАЛТ№1

АЮУЛЫГ МЭДЭЭЛЭХ ХУУДАС №

Огноо...../...../.....ЦАГ:.....
 Байрлал:.....
 Аюул:

Хохирлын төрөл: Амь нас эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин, ААД, ТАД-ийн зөрчил, галын аюул, бусад /Зурах/

Хохирлын хэмжээ

НОЦТОЙ ИХ ДУНД БАГА ЯЛИМГҮЙ

Авбал зохих арга хэмжээ:

.....

Хувийн№..... Утас:.....
 Мэдээлэгч:..... Гарын үсэг:.....
 Хэнд мэдээлсэн.....
 Авсан арга хэмжээ.....

Арга хэмжээ авсан:.....
 Огноо:...../...../.....Цаг.....



Аюулын төрөл	Тийм	Игүй	Аюулын төрөл	Тийм	Игүй	Аюулын төрөл	Тийм	Игүй	Аюулын төрөл	Тийм	Игүй	Аюулын төрөл	Тийм	Игүй
Ажлын байр, орчин			Аюулын төрөл			Аюулын төрөл			Аюулын төрөл			Аюулын төрөл		
Хязгаарлагдмал орон зай			Цахилгаан нум			Гэрэл			Өөртөө эрдэх			Лазер		
Давчуу орон зай			Хяналтын системийн эвдрэл			Гялбах			Ядаргаа			Цацраг идэвхит тоос		
Тэгш бус шал/нурсан газар			Тогтмол хүчдэлийн задгай/богино холболт			Их/бага түвшин			Санаа зоволт			Цацраг идэвхийн хэмжүүр		
Агааржуулалт хангалтгүй			Соронзон орон			Механик			Бодлого/дүрэм журамд үл захирагдах байдал			Радио давтамж ба богино долгион		
Нойтон хальтиргаатай шал, газар			Цахилгаанжилт			Бутрах			Оюун ухааны ажиллах чадвар буурсан			Нил ягаан туяа		
Усны нөөц ашиглалт/голдирлын өөрчлөлт			Ажиллах нөхцөл			Тасарч унах			Биеийн ажиллах чадвар буурсан			Үзэгдэх гэрэл		
Цаг уур/байгалийн үзэгдлүүд			Биед эвгүй байрлал			Цохих			Дуу чимээ/Чичиргээ			Гагнуурын оч		
Хэт халуун			Бөхийсөн/мушгирсан н/дээш сунасан байрлал			Эргэлдэх механизм			Шуугиан (Үргэлжилсэн)					
Манан/будантай, харах орчин хязгаарлагдмал			Гар багаж хэрэглэх нь тухайн ажил үүрэгт тохирсон эсэх			Хаалт хамгаалалтгүй тоног төхөөрөмж			Шуугиан (гэнэтийн, огцом)					
Мөс			Гар ажиллагаа/ачаа ачих буулгах			Нөөцлөгдсөн энерги огцом гадагшлах			Биологийн аюул					
Намаг			Түлхэх/татах			Цоож пайзны систем хэрэглээгүй аюултай энергийн эх үүсвэр			Бактери, вирусын халдвар					
			Давтагдсан хөдөлгөөнүүд			Дулаан/Гал/Гэсрэлт			Цусаар халдварлах					

ДАРХАНЫ ДУЛААНЫ
 СҮЛЖЭЭ ТӨХК
 ХУУЛБАР ҮНЭН
 Хуулбар өгссөн ажлын үеэр
 2019 оны 4 сарын 30-ний өдөр

36/2019

Биеийн Ли - 3333
халдварлах

Бороо	Хориотой бүс	Хүйтэн гадаргуу; Хүйтний нөлөө/хэт хүйтэн	Даралт	Халдварлах
Цас	Чичиргээ- гар / шуу	Халуун гадаргуу, халууны нөлөө, хэт халуун	Агаарын (шахагдсан)	Халдварт өвчин халдварлах
Салхи, шуурга	Чичиргээ-бүх бие Ажлын байрны зохион байгуулалт	Тэсэлгээ-тоос/хий Тэсэлгээ-нээлттэй цооногт/газар дээр Гал	Тосон/гидравлик-усны Хийн Урсгалын Уурын	Шавьж/аалз хазах Тариур зүүгээр халдварлах Зэрлэг амьтдын халдлага
Гадны аюул				
Онц байдал зарласан (сэрэмжлүүлэг ба нүүлгэн шилжүүлэлт)	Тэгш газарт унах	Химийн бодис	Усны	Шатамхай шингэн ба биет
Хорлон сүйтгэх ажил/гал тавих	Өндрөөс унах	Химийн элементүүд- холимог шингэлэгчүүдийн ууршилт		
Зөвшөөрөгдөөгүй хүн/амьтан орж ирэх боломжтой	Хүнд зүйл унах	Химийн бодисын асгаралт, түлэгдэлт		Шатахуун (бензин)
Цахилгаан/соронзон орон				
Хувьсах нам хүчдэл	Эд зүйл, ачаа нурах	Хувийн зан авир	Цацраг - Ионжсон/Ионжсон бус	Тоснууд
Хувьсах өндөр хүчдэл (>380 вольт)	Эд зүйл, ачаа холбирах, өнхрөх	Хэт удаан ажиллах Түрэмгий зан	Цахилгаан соронзон долгион Гамма/рентген цацраг/рентген аппаратууд	Будаг шинглэгч Шингэн хийн түлш (пропан)
	Саваа цохих	Архи/мансууруулах бодис хэрэглэх	Хэт улаан туяа	Нүүрстөрөгч

Хуульчдын дулааны
СҮЛЖЭЭ ТӨХК
ХУУЛБАР ҮНЭН
Хуульч олгосон ажилтны гарын үсэг
2019 оны 4 сарын 30-ний өдөр

Зөрчил үүсэх магадлал	Давтагдах хугацаа	P
Тохиолдлын	3-5 жилд	1
Бага магадлалтай	Нэг жилд	2
Магадлалтай	Улиралд	3
Сүүдөр магадлалтай	Сард	4
Тогтмол	Долоо хоногт	5

Хүснэгт 2.

Зөрчлөөс шалтгаалах үр дагавар	Тусламж авах хугацаа	N
Хөдөлмөрийн чадвар алдагдах байдал хүргэхгүйгээр эрүүл мэндэд бага хэмжээний хохирол учруулах гэмтэл	Түр саатах	1
Хөдөлмөрийн чадвар алдалттай боловч эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагагүй хөнгөн гэмтэл	Ээлжийн дотор	2
Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай ноцтой гэмтэл	4 хоног хүртэл	3
Удаан хугацааны эмчилгээ шаардлагатай ноцтой гэмтэл	4 хоногоос дээш	4
Амь нас эрсдэхэд хүргэх гэмтэл	Удаан	5

Хүснэгт 3.

Гишүүдийн санал	H
Гэмтэл, бэртэлд хүргэх маш бага магадлалтай	1
Гэмтэл, бэртэлд хүргэх бага магадлалтай	2
Гэмтэл, бэртэлд хүргэх их магадлалтай	3
Гэмтэл, бэртэлд хүргэх үлэмж их магадлалтай	4

Идгээр хүсэгтийг ашиглан Маягт 2-ын дагуу бодолт хийнэ.

$$R=P*N*H$$

- H Эрсдлийн түвшин
- P Зөрчил үүсэх магадлал
- N Зөрчлөөс шалтгаалах үр дагавар
- H Гишүүдийн санал

Маягт 1.1: Ажилтнаас шалтгаалах зөрчил

№	Зөрчил	P	N	H
1	ХАБЭА-н сургалтанд хамрагдаагүйгээс			
2	Эрүүл мэндийн хувьд тухайн ажил тэнцээгүйгээс			
3	Хийх ажлаа мэддэггүйгээс			
4	Мэргэжлийн сургалтанд хамрагдаагүйгээс			
5	Ажлын хувцас хамгаалах хэрэгслээ зөв хэрэглэж сураагүйгээс			
6	Ажлын байрандаа хяналт хийдэггүйгээс			
7	Анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлж чадаагүйгээс			
8	Онцгой байдлын үед өөрийгөө болон бусдыг аврах мэдлэггүйгээс			
9				

Тайлбар: Тухайн ажлын байрны онцлогт тохируулан судалгааны асуулгыг өөрчилж хэрэглэнэ.

Маягт 1.2: Тоног төхөөрөмжөөс шалтгаалах зөрчил

- Тоног төхөөрөмжийн нэр
- Марк
- Ашиглалтанд орсон огноо
- Цех тасгийн нэр



Зөрчил	P	N	H
Цахилгаан тоног төхөөрөмж			
Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглах, ажиллуулах зааваргүйгээс			
Цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулга хийдэггүйгээс			
Техник ашиглалтын паспорт хөтөөгүйгээс			
Тоног төхөөрөмжийн удирдлагын систем бүрэн бишээс			
Аваарийн зогсоогуур суурилуулаагүйгээс			
Зөв суурилуулалт хийгээгүйгээс			
Даралтат сав, шугам хоолой			
Ашиглах зөвшөөрөлгүйгээс			
Даралтын баталгаажилт хийгдээгүйгээс			
Хэмжих хэрэгслийн баталгаажуулаагүйгээс			
Металлын шинжилгээ хийгээгүйгээс			
Хамгаалах хавхлаг ажилладаггүйгээс			
Эргэх зөөх механизм			
Даацын баталгаажилт хийгээгүйгээс			
Оосорлох хэрэгслийг туршаагүйгээс			
Тоормосны механизм гэмтэлтэйгээс			
Хязгаарлалт ажилладаггүйгээс			
Багаж хэрэгсэл, түүхий эд материал			
Багаж хэрэгслийн бариул эргономикийн шаардлага хангаагүйгээс			
Багаж хэрэгслийг зөв байрлуулаагүйгээс			
Багаж хэрэгслийн эвдрэлээс			
Ашиглах зөвшөөрөл аваагүйгээс			
Түүхий эд материалын бохирдолтоос			
Түүхий эд материалыг зөв хадгалаагүйгээс г.м			

Тайлбар: Химийн бодис, уур усны ялгаруулалт гэх мэт тоног төхөөрөмжид тавигдах аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага стандарт, ямар тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд эрсдэлийн үзүүлэлт хийж байна гэдгээс хамаарч тухайн тоног төхөөрөмжид тавигдах аюулгүй ажиллагааны үзүүлэлт авахдаа онцлогоос шалтгаалан асуулгыг өөрчилж болно.

Маягт 1.3. Ажлын байрны орчин, нөхцөлөөс шалтгаалах зөрчил

Ажлын байрны нэр

Цах тасгийн нэр

Ажил мэргэжлийн нэр

Зөрчил	P	N	H
Физикийн хүчин зүйл			
1 Ажлын байрны агаарын температур зөвшөөрөгдөх хэмжээнээс их ба бага			
2 Агаарын урсгалын хурд зөвшөөрөгдөх хэмжээнээс их ба бага			
3 Харьцангуй чийглэг зөвшөөрөгдөх хэмжээнээс их ба бага			
4 Гэрэлтүүлэг зөвшөөрөгдөх хэмжээнээс их ба бага			
5 Дуу, шуугиан зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
6 Доргион зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
7 Цахилгаан соронзон орон зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
Химийн хүчин зүйл			
8 Угаарын хий зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
10 Нүүрсхүчлийн хий зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
11 Азотын исэл зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
12 Хүхэрлэг ангидрид зөвшөөрөгдөх хэмжээнээс их			
13 Хүхэрт устөрөгч зөвшөөрөгдөх хэмжээнээс их			

Бүртгэлийн дугаар ... 36/2019

ДАРХАНЫ ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК

ХУУЛБАР ҮНЭН

Хуульбар олгосон ажлын газрын үсэг

2019 оны 4 сарын 30 өдөр

Биологийн хүчин зүйл

Ажлын байран дахь хөгц мөөнгөнцөр үүссэн			
Халдвартай материалтай харьцаж ажилладаг			
Ажилтнуудын цайны газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангалтгүй			
Бие засах, усанд орох газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангалтгүй			
Өвчин үүсгэгч жижиг организмаас халдарлах (бактер, вирус)			

Тайлбар: Тухайн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хийсэн дүнг үндэслэж энэхүү маягтыг бөглөнө.

Маягт 1.4. Ажил олгогч, удирдлагаас шалтгаалах зөрчил

- Цөж тасгийн нэр
- Ажлын байрны нэр
- Удирдагчийн нэр

Зөрчил	P	N	H
Аюулгүй байдлын төлөвлөгөөгүйгээс			
Эрсдэлийн үнэлгээ хийгээгүйгээс			
ХАБЭА-н санхүүжилтийг зөв төлөвлөөгүйгээс			
Дотоод хяналт хийдэггүйгээс			
Ажлын гүйцэтгэх дэс дарааллыг зөв тогтоогоогүйгээс			
Ажил эхлэх, дуусах болон явцын хяналтыг хийдэггүйгээс			
Осол болон осол дөхсөн тохиолдлыг судалдаггүйгээс			

Тайлбар: Ажлын байр тус бүрээр ажил олгогч, удирдлагаас шалтгаалах зөрчлийн судалгааг дээрх маягтын дагуу авна.

Маягт 2. Эрсдэлийн түвшинг тогтоох нэгдсэн хүснэгт

Бүгийн гишүүд	Эрсдэлийн түвшин	Ажилтнаас шалтгаалсан зөрчил						
		Асуулт 1	Асуулт 2	Асуулт 3	Асуулт 4	Асуулт 5	Асуулт 6	Асуулт 7
1-р гишүүний санал	P							
	N							
	H							
2-р гишүүний санал	P							
	N							
	H							
3-р гишүүний санал	P							
	N							
	H							
Нийт дундаж үнэлгээ	P							
	N							
	H							
Тоон үнэлгээ								
Үсгэн үнэлгээ								

Тайлбар: Маягт 2-ын дагуу Тоног төхөөрөмжөөс шалтгаалсан зөрчил Ажлын байрны орчин, нөхцөлөөс шалтгаалсан зөрчил Ажил олгогч, удирдагчаас шалтгаалсан зөрчил гэсэн хүснэгтүүдийг хийнэ. Нийт дундаж үнэлгээг өгөхдөө гишүүд тус бүрийн P,N,H магадлалуудад өгсөн үнэлгээний нийлбэрийн дундажаар гаргана.

Бүртгэлийн дугаар *36/2019*

ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТӨХК

ХУУЛБАР ҮНЭН

Хуульбар олгосон ажилтны гарын үсэг

2019 оны 4 сарын 20-ний өдөр

Эрсдэлийн ангилал	Эрсдэлийн түвшин R	Авах арга хэмжээ
A	R ≥ 100 үл зөвшөөрөгдөх хэмжээнээний эрсдэл	Эрсдэлийн түвшин нь маш өндөр байна. Зөрчлийн нөлөөлөл хүчин зүйлс нь бэртэл, гэмтэл, ноцтой осолд хүргэж болзошгүй учраас ажлыг гүйцэтгэж эхлэх ба үргэлжлүүлж болохгүй. Хэрэгжүүлэх арга хэмжээний зардал, өртгөөс үл хамааран эрсдэлийг нэн даруй бууруулах арга хэмжээ авах шаардлагатай.
B	R = 51-99 тохиромжгүй, ихээхэн хэмжээний эрсдэл	Эрсдэлийн түвшин нь өндөр байна. Эрсдэлийг илүү хүлээн зөвшөөрөхүйц түвшин хүртэл бууруулах, аюулгүй байдлын арга хэмжээг яаралтай авахад чиглэгдсэн хөрөнгийг гаргах шаардлагатай.
C	R = 11-50 дундаж хэмжээний эрсдэл	Эрсдэлийн түвшин нь дундаж хэмжээтэй байна. Хэдийгээр яаралтай биш ч гэсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм, дүрмийн дагуу аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай.
D	R = 4-10 зөвшөөрөгдөх хэмжээний эрсдэл	Эрсдэлийн түвшин нь маш бага байна. Ажил гүйцэтгэх үед тогтмол хяналт тавьж, эрсдэлийг удирдах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм, дүрмийг хатуу мөрдлөг болгох шаардлагатай.
E	R = 1-3 бага хэмжээний эрсдэл	Эрсдэлийн түвшин нь маш бага байна. Эрсдэлийг удирдах онцгой арга хэмжээ шаардлагагүй боловч, үүнийг 100% аюулгүй нөхцөл байдлыг хангасан гэж үзэж болохгүй.

Маягт 3. Эрсдэлийг тогтоосноор зөрчлийг арилгах төлөвлөгөө боловсруулах

Ажилбарын нэр	Хүчин зүйл	Үүссэн зөрчил	Эрсдэлийн түвшин R	Авах арга хэмжээ	Хариуцах ажилтан	Хугацаа	Санхүүжилт
Ажилтан		1. Зөрчил 1	A	Авах арга хэмжээ 1 ААХ-2			
		2. Зөрчил 1	B				
		3. Зөрчил 1	C				
		4. Гэх мэт	D				
Тоног төхөөрөмж		1. Зөрчил 1	C	ААХ-1 ААХ-2 гэх мэт			
		2. Зөрчил 1	B				
		3. Зөрчил 1	A				
		4. Гэх мэт	E				
Ажлын байрны орчин, нөхцөл		1. Зөрчил 1	A	ААХ-1 ААХ-2 гэх мэт			
		2. Зөрчил 1	B				
		3. Зөрчил 1	C				
		4. Гэх мэт	D				
Ажил олгогч буюу удирдлага		1. Зөрчил 1	D	ААХ-1 ААХ-2 гэх мэт			
		2. Зөрчил 1	A				
		3. Зөрчил 1	C				
		4. Гэх мэт	E				

Тайлбар: Төлөвлөгөөний дагуу зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах албан тушаалтныг тодорхой болгож өгөх хэрэгтэй. Ингэхдээ тухайн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг үндэслээрэй. Тухайн зөрчлийг арилгахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийг тодорхойлохдоо зах зээлийн үнийг баримтлаарай.

Тухайлбал: Тоног төхөөрөмжөөс шалтгаалсан зөрчилд авах арга хэмжээ:

- Засах
- Орлуулах
- Шинэчлэх
- Хамгаалах хэрэгсэл хэрэглэх

